*“ҮТС-2019” хуралд зориулав.*

# ҮНДЭСНИЙ ТООЦООНЫ ДАНС
## /ӨРХИЙН СЕКТОР/

ҮНДЭСНИЙ ТООЦОО, ШИНЖИЛГЭЭ СУДАЛГААНЫ
ГАЗРЫН СТАТИСТИКЧ Ц.ТЭГШЖАРГАЛ

2019-12-12

# Агуулга

I. Үндэсний тооцооны секторын данс

II. Өрхийн секторын данс

# 1. Үндэсний тооцооны дансны ойлголт

- Үйлдвэрлэл хэрхэн явагдаж, орлого хэрхэн бий болж, хуваарилагдаж байгаа, орлогынхоо хэдийг нь хэрэглэж, хир хэмжээтэйг хадгалж, хадгаламж нь юунд зарцуулагдаж байгаа зэрэг эдийн засгийн үйлдлүүдийг үндэсний тооцооны данс нэгтгэн харуулна.

- Үндэсний тооцооны дансууд нь эдийн засгийн үйл ажиллагааны талаарх мэдээлэл, тухайлбал эдийн засаг дахь үйлдвэрлэлийн хэмжээ, хүн амын бэл бэнчин, хөрөнгийн хэмжээг тодорхой хугацааны байдлаар харуулж чаддагаараа ихээхэн ач холбогдолтой.

- Үндэсний тооцооны дансууд нь  үйлдвэрлэл, хэрэглээ, хуримтлалыг үе шаттайгаар харуулахаас гадна, эдийн засгийн сектороор илэрхийлнэ.

- Үндэсний тооцооны дансууд нь дараалсан дансууд байх бөгөөд нэг дансны үлдэгдэл үзүүлэлт буюу баланслуулах үзүүлэлт нь дараагийн дансны эхний үлдэгдэл болдог.

# 1. Үндэсний тооцооны дансны талаар

- Үндэсний тооцооны дансыг дотор нь *урсгал данс* ба *хуримтлалын* данс гэж 2 ангиддаг

- Үйлдвэрлэлийн данс, орлого бүрдэлтийн данс, анхдагч орлогын хуваарилалтын данс, орлогын дахин хуваарилалын данс, орлого ашиглалтын данс нь урсгал дансыг бүрдүүлдэг.

- Хөрөнгийн болон санхүүгийн данс, түүнчлэн хөрөнгийн бусад өөрчлөлтийн данс, хөрөнгийн дахин үнэлгээний данс, актив пассивын данс нь хуримтлалын дансыг бүрдүүлдэг.

- Урсгал дансууд дахь эдийн засгийн үйлдлүүд нь актив, пассивын тэнцэлд шууд нөлөө үзүүлдэггүй бол хуримтлалын дансуудад тусгагдсан эдийн засгийн үйлдлүүдийн үр дүн нь актив, пассивын тэнцэлд нөлөөлдөг.

- Үндэсний тооцооны дансанд тусгасан үзүүлэлт бүр эдийн засгийн тодорхой үйл ажиллагааг харуулах бөгөөд энэ нь эдийн засгийн нэг секторын авсан, нөгөө секторын өгсөн үйлдлийг агуулж байдаг тул түүнийг илэрхийлэх нөөц ба ашиглалт гэсэн хоёр хэсгээс бүрдэж нөөц талд авсныг, ашиглалт талд өгснийг харуулна.

# 1.1 Үндэсний тооцооны дансны хамрах хүрээ



# 1.2 Үндэсний тооцооны дансанд ашиглах ангилал

Эдийн засгийн секторын ангилал:

- *Санхүүгийн бус сектор*: Зах зээлд борлуулахаар бүтээгдэхүүн үйлдвэрлэж, санхүүгийн бус үйлчилгээ үзүүлж, орлогоороо зардлаа нөхдөг бие даасан аж ахуйн нэгжийг санхүүгийн бус секторт хамруулна. Үйлдвэрлэл, үйлчилгээний салбарт буюу санхүүгийн бус салбарт зах зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй ашгийн бус байгууллагуудыг энэ секторт хамруулна.

- *Санхүүгийн сектор:* Санхүүгийн зуучлагчид, түүнтэй холбоотой туслах үйл ажиллагаа эрхэлдэг нэгжийг санхүүгийн секторт багтааж ойлгоно. Санхүүгийн салбарт зах зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй ашгийн бус байгууллагуудыг мөн энэ секторт хамруулна.

- *Төрийн байгууллагын сектор:* Төр, засгийн байгууллага үйл ажиллагаандаа зориулж орлого бүрдүүлэн, мөн түүнийгээ тодорхой чиглэлээр зарцуулж байгаагийн хувьд эдийн засгийн энэхүү секторт хамаарах нэгж болно.

- *Өрхийн сектор:* Өөрийн эцсийн хэрэглээнд, эсвэл зах зээлд борлуулахаар үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг өрхүүдийг өрхийн аж ахуйн секторт хамруулна. Өрх нь үйлдвэрлэгч байхаас гадна зах зээлд ажиллах хүч нийлүүлэгч, мөн эцсийн хэрэглэгч байна. Өрхийн аж ахуйн үйлдвэрлэгчид нэгдэн хоршдоггүй бөгөөд бие даасан тайлан баланс гаргах боломжгүй байдаг.

- *Өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллагын сектор:* Өөрийн гишүүд болон өрхүүдэд бараа, бүтээгдэхүүнийг борлуулах, үйлчилгээг үзүүлэхдээ үнэ төлбөргүй юм уу эсвэл зах зээлийн үнээс доогуур үнээр борлуулдаг, үүсгэн байгуулагч болон тэдгээрийг санхүүжүүлэгч, удирдах нэгждээ ашиг олох хэрэгсэл нь болдоггүй ашгийн бус байгууллагууд энэ секторт хамрагдана.

- *Гадаад эдийн засгийн сектор:*

# 1.3 Эдийн засгийн нэгдсэн данс, сектороор



# 1.4 Үндэсний тооцооны дансны мэдээллийн эх үүсвэр

| | ДНБ | | | ТТ | ЗГСС | МСС |
|---|---|---|---|---|---|---|
| | Ү | О | Э | | | |
| 1. Үйлдвэрлэлийн данс | + | | | | + | |
| 2. Орлого бүрдэлтийн данс | | + | | | + | |
| 3. Анхдагч орлогын хуваарилалтын данс | + | | | + | + | |
| 4. Орлогын дахин хуваарилалтын данс | | | | + | + | |
| 5. Орлого ашиглалтын данс | | | + | | + | |
| 6. Хөрөнгийн данс | | | | + | + | |
| 7. Санхүүгийн данс | | | | + | + | + |

# 1.5 Үндэсний тооцооны дансны үзүүлэлтүүд

| | Дансууд | Тайлбар |
|---|---|---|
| 1 | Үйлдвэрлэлийн данс | Үйлдвэрлэл хэрхэн явагдаж буйг харуулна.  Балансын үзүүлэлт –**ДНБ** |
| 2 | Орлого бүрдэлтийн данс | Орлого хэрхэн бүрэлдэж бий болж буйг харуулна. Балансын үзүүлэлт нь **– Ашиг холимог орлого** |
| 3 | Анхдагч орлогын хуваарилалтын данс | Нийт эдийн засгийн хувьд анхдагч орлогын байршлыг харуулдаг.  Балансын үзүүлэлт нь-**ҮНО** |
| 4 | Орлогын дахин хуваарилалтын данс | Анхны орлогын үлдэгдэл урсгал шилжүүлгийн дүнд хэрхэн эзэмшлийн орлого болж хувирч байгааг харуулна. Балансын үзүүлэлт нь - **ҮЭНО** |
| 5 | Орлого ашиглалтын данс | Эзэмшлийн орлогын ашиглалтыг харуулна. Балансын үзүүлэлт нь – **Хадгаламж** |
| 6 | Хөрөнгийн данс | Хөрөнгийн хуримтлал, түүний санхүүжилтийн эх үүсвэрийг харуулдаг. Балансын үзүүлэлт **-Цэвэр зээлжүүлэлт/цэвэр өглөг** |
| 7 | Санхүүгийн данс | Сектор хооронд болон гадаад сектортой хийсэн санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн өөрчлөлтийг харуулна. Балансынүзүүлэлт - Цэвэр зээлжүүлэлт/цэвэр өглөг |
| 8 | Хөрөнгийн биет хэмжээний өөрчлөлтийн данс | ЭЗ-ийн ү/а-ны дүнд бус байгалийн аюулт үзэгдэл, дайн байлдаан, нийтийг хамарсан өвчин зэргийн улмаас бий болсон алдагдал/ шинээр бий болсон хөрөнгийн өөрчлөлт бүртгэнэ. Балансын үзүүлэлт - Хөрөнгийн цэвэр өртөг |
| 9 | Хөрөнгийн дахин үнэлгээний данс | Санхүүгийн хөрөнгөд гарсан үнийн өөрчлөлтийг харуулна. Үнийн өсөлтийн олз /гарз |
| 10 | Актив, пассивын тэнцэл | Хөрөнгийн дансдын нэгтгэл,  Эхлэлтийн баланс –Тайлант үед гарсан өөрчлөлт- эцсийн баланс |

# 1.4 Үндэсний тооцооны дансны үзүүлэлтүүд






# 1.6 Эдийн засгийн секторын данс, сая төгрөг

### 1. Үйлдвэрлэлийн данс, 2018

| Ашиглалт | | | | | Үйл ажиллагаа ба балансулуулах үзүүлэлт | | Нөөц | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| S.14,15 | S.13 | S.12 | S.11 | S.1 | | | S.1 | S.11 | S.12 | S.13 | S.14,15 |
| | | | | | P.1 | Нийт үйлдвэрлэлт | 60755.0 | 41744.8 | 2166.5 | 4066.0 | 12777.6 |
| 4323.3 | 1438.2 | 625.2 | 25578.5 | 31965.3 | P.2 | Завсрын хэрэглээ | | | | | |
| 8454.3 | 2627.8 | 1541.3 | 16166.2 | 28789.6 | **B.1g** | **Нийт нэмэгдэл өртөг** | | | | | |
| | | | | | D.21-D.31 | Бүтээгдэхүүний татвар хасах нь татаас | 3517.7 | | | | |
| | | | | 32307.3 | **B.1g+1** | **Дотоодын нийт бүтээгдэхүүн** | | | | | |

### 2. Орлого бүрдэлтийн данс, 2018

| Ашиглалт | | | | | Үйл ажиллагаа ба балансулуулах үзүүлэлт | | Нөөц | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| S.14,15 | S.13 | S.12 | S.11 | S.1 | | | S.1 | S.11 | S.12 | S.13 | S.14,15 |
| | | | | | B1/g | Нэмэгдэл өртөг/Дотоодын бүтээгдэхүүн, нийт | 32307.3 | 16166.2 | 1541.3 | 2627.8 | 8454.3 |
| 538.2 | 2064.5 | 406.7 | 5397.7 | 8407.2 | D1 | Ажиллагчдын хөдөлмөрийн хөлс | | | | | |
| | | | | 3645.6 | **D21** | Бүтээгдэхүүний татвар | | | | | |
| 0.0 | 0.0 | 10.1 | 156.4 | 166.5 | **D29** | Үйлдвэрлэлийн бусад татвар | | | | | |
| | | | | 127.9 | **D31** | Бүтээгдэхүүний татаас | | | | | |
| 0.0 | 0.0 | 0.0 | 26.0 | 26.0 | **D39** | Үйлдвэрлэлийн бусад татаас | | | | | |
| 7916.1 | 563.3 | 1124.5 | 10638.2 | 20242.0 | **B2g** | **Үйл ажиллагааны ашиг /холимог орлого, нийт** | | | | | |

### 3. Анхдагч орлого хуваарилалтын данс, 2018

| Ашиглалт | | | | | Үйл ажиллагаа ба балансулуулах үзүүлэлт | | Нөөц | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| S.14,15 | S.13 | S.12 | S.11 | S.1 | | | S.1 | S.11 | S.12 | S.13 | S.14,15 |
| | | | | | B2g | Үйл ажиллагааны ашиг /холимог орлого, нийт | 20242.0 | 10638.2 | 1124.5 | 563.3 | 7916.1 |
| | | | | | D1 | Ажиллагчдын хөдөлмөрийн хөлс | 8863.9 | | | | 8863.9 |
| | | | | | **D21** | Бүтээгдэхүүний татвар | 3645.6 | | | 3645.6 | |
| | | | | | **D31** | Бүтээгдэхүүний татаас | 127.9 | | | 127.9 | |
| | | | | | **D29** | Үйлдвэрлэлийн бусад татвар | 166.5 | | | 166.5 | |
| | | | | | **D39** | Үйлдвэрлэлийн бусад татаас | 26.0 | | | 26.0 | |
| 1694.9 | 1046.4 | 3337.0 | 3866.2 | 9944.5 | **D4** | **Өмчийн орлого** | 6435.6 | 301.8 | 4296.1 | 615.7 | 1222.0 |
| 16307.1 | 3790.8 | 2083.6 | 7073.7 | 29255.2 | **b5g/b5*g** | **Анхны орлогын үлдэгдэл/ Үндэсний орлого, нийт** | | | | | |

# 1.5 Эдийн засгийн секторын

**4. Орлогын дахин хуваарилалтын данс, 2018**

| Ашиглалт | | | | | Үйл ажиллагаа ба баланслуулах үзүүлэлт | | Нөөц | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| S.14,15 | S.13 | S.12 | S.11 | S.1 | | | S.1 | S.11 | S.12 | S.13 | S.14,15 |
| | | | | | b5g/b5*g | Анхны орлогын үлдэгдэл/ үндэсний орлого, нийт | 29255.2 | 7073.7 | 2083.6 | 3790.8 | 16307.1 |
| 850.0 | 0.0 | 165.2 | 1111.7 | 2127.0 | D5 | Орлогын ба хөрөнгийн татвар | 2127.0 | | | 2127.0 | |
| 1638.3 | | | | 1638.3 | D61 | Нийгмийн даатгалын шимтгэл | 1638.3 | | | 1638.3 | |
| | 2407.5 | | | 2407.5 | D62 | Нийгмийн халамжийн тэтгэмж | 2407.5 | | | | 2407.5 |
| 124.2 | 424.5 | 79.2 | 407.1 | 1034.9 | D7 | Урсгал шилжүүлэг | 1835.2 | 45.4 | 130.8 | 779.5 | 879.5 |
| 16981.6 | 5503.6 | 1969.9 | 5600.3 | 30055.4 | **b6.g** | **Эзэмшлийн орлого, нийт** | | | | | |

**5. Орлого ашиглалтын данс, 2018**

| Ашиглалт | | | | | Үйл ажиллагаа ба баланслуулах үзүүлэлт | | Нөөц | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| S.14,15 | S.13 | S.12 | S.11 | S.1 | | | S.1 | S.11 | S.12 | S.13 | S.14,15 |
| | | | | | b6.g | Эзэмшлийн орлого, нийт | 30055.4 | 5600.3 | 1969.9 | 5503.6 | 16981.6 |
| 16402.4 | 3782.1 | | | 20184.6 | P.3 | Эцсийн хэрэглээний зардал | | | | | |
| 579.1 | 1721.5 | 1969.9 | 5600.3 | 9870.9 | **B.8g** | **Хадгаламж, нийт** | | | | | |

**6. Хөрөнгийн данс, 2018**

| Хөрөнгөд гарсан өөрчлөлт | | | | | Үйл ажиллагаа ба баланслуулах үзүүлэлт | | Өр төлбөр болон хөрөнгийн цэвэр өртөгт гарсан | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| S.14,15 | S.13 | S.12 | S.11 | S.1 | | | S.1 | S.11 | S.12 | S.13 | S.14,15 |
| | | | | | B.8n | Хадгаламж, цэвэр | 6937.7 | 3340.8 | 1865.3 | 1158.2 | 573.4 |
| 1196.8 | 1357.2 | 286.6 | 11081.1 | 13921.7 | P.5 | Хөрөнгийн нийт хуримтлал | | | | | |
| 1193.5 | 1349.7 | 253.3 | 6834.1 | 9630.5 | **P.51g** | Үндсэн хөрөнгийн нийт хуримтлал | | | | | |
| -5.7 | -563.3 | -104.6 | -2259.5 | -2933.1 | P.51c | Үндсэн хөрөнгийн хэрэглээ | | | | | |
| 3.3 | 7.6 | 33.4 | 4246.1 | 4290.4 | P.52 | Материаллаг эргэлтийн хөрөнгийн нөөцийн өөрчлөлт | | | | | |
| 0.0 | 0.0 | 0.0 | 0.9 | 0.9 | P.53 | Үнэт зүйлсийн нөөцийн өөрчлөлт | | | | | |
| | | | | 0.0 | D.9r | Хөрөнгийн шилжүүлгүүд, авсан /+/ | 1919.0 | 1830.5 | 0.0 | 88.5 | 0.0 |
| | | | | 0.0 | D.9p | Хөрөнгийн шилжүүлгүүд, өгсөн /-/ | 1690.8 | 0.0 | 0.0 | 1690.8 | 0.0 |
| | | | | 0.0 | B.10.1 | Хадгаламж, хөрөнгийн шилжүүлэгт гарсан хөрөнгийн өөрчлөлт | 7166.0 | 5171.3 | 1865.3 | -444.1 | 573.4 |
| | | | -1.4 | -1.4 | | Статистик зөрүү | | | | | |
| -617.6 | -1238.0 | 1683.3 | -3651.6 | -3824.0 | **B.9g** | **Цэвэр зээлжүүлэлт (+)/ цэвэр өглөг(-)** | | | | | |

# 2. Өрхийн секторын данс, сая төгрөг

| ОРЛОГО | | | | | | ОРЛОГО АШИГЛАЛТ | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2018 | 2017 | 2016 | 2015 | 2014 | | 2014 | 2015 | 2016 | 2017 | 2018 |
| | | | | | **Анхдагч орлого, хүлээн авсан / төлсөн** | | | | | |
| 7916.1 | 6818.5 | 6539.0 | 6630.4 | 5770.2 | Нийт ашиг, холимог орлого | | | | | |
| 8863.9 | 7330.1 | 6539.0 | 6165.0 | 5646.4 | Ажиллагчдын хөдөлмөрийн хөлс | | | | | |
| 1222.0 | 1222.0 | 971.0 | 843.1 | 759.7 | Өмчийн орлого | 512.7 | 666.9 | 1141.2 | 1316.8 | 1694.9 |
| 18001.9 | 15370.6 | 14049.0 | 13638.5 | 12176.3 | Дүн | 512.7 | 666.9 | 1141.2 | 1316.8 | 1694.9 |
| | | | | | **Орлогын дахин хуваарилалтын орлого, хүлээн авсан / өгсөн** | | | | | |
| | | | | | Урсгал шилжүүлэг, авсан / өгсөн | | | | | |
| 2407.5 | 2126.0 | 1962.7 | 1849.9 | 1602.6 | тэтгэвэр, тусламж | | | | | |
| | | | | | орлогын татвар | 503.2 | 504.4 | 547.8 | 684.8 | 850.0 |
| | | | | | нийгмийн даатгалын шимтгэл | 917.6 | 1018.2 | 1109.8 | 1321.4 | 1638.3 |
| 879.5 | 786.3 | 726.1 | 462.5 | 414.2 | бусад урсгал шилжүүлэг | 1.4 | 2.8 | 122.5 | 121.7 | 124.2 |
| 3287.0 | 2912.3 | 2688.8 | 2312.3 | 2016.8 | Дүн | 1422.1 | 1525.4 | 1780.1 | 2127.9 | 2612.5 |
| **21288.9** | **18282.8** | **16737.8** | **15950.8** | **14193.1** | **Нийт орлого, хүлээн авсан / төлсөн** | **1934.8** | **2192.3** | **2921.3** | **3444.7** | **4307.3** |
| | | | | | **Эзэмшлийн нийт орлого** | **12258.3** | **13758.6** | **13619.2** | **14838.2** | **16981.6** |
| | | | | | Эцсийн хэрэглээний зардал | 12587.6 | 13671.2 | 13001.5 | 14922.2 | 16402.4 |
| | | | | | Нийт хадгаламж | -329.3 | 87.4 | 617.7 | -84.0 | 579.1 |

# 2.1 Өрхийн секторын дансны зарим үзүүлэлтүүд












# 2.2 Зарим холбогдох үзүүлэлтүүд

| | 2014 | 2015 | 2016 | 2017 | 2018 |
|---|---|---|---|---|---|
| **Татварын орлого** | 5157.0 | 5119.0 | 4951.0 | 6315.1 | 8207.1 |
| Хувь хүний орлогын албан татвар | 507.9 | 520.0 | 566.2 | 695.1 | 850.4 |
| Дүнд эзлэх хувь | 9.8 | 10.2 | 11.4 | 11.0 | 10.4 |
| | | | | | |
| **Урсгал зардал** | 5293.4 | 5718.4 | 6613.8 | 7043.2 | 7348.0 |
| Өрхийн хүлээн авсан урсгал шилжүүлэг | 1595.1 | 1849.9 | 1962.7 | 2126.0 | 2406.6 |
| Дүнд эзлэх хувь | 30.1 | 32.3 | 29.7 | 30.2 | 32.8 |

# Анхаарал тавьсанд баярлалаа